

## “90-ЭЭД ОНЫ МОНГОЛ-ХЯТАДЫН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА”

(Тайваньд хэвлэгдсэн номын шүүмж)

Ч.Батцэцэг<sup>x</sup>

Тайваний Монгол-Түвдийн Хорооноос жил тутам Монголын асуудлаар төрөлжсөн судалгаа явуулж судлагдахуунаа дотоодын хэрэгцээндээ хэвлэн нийтлэхээс гадна уг байгууллагын мэргэжилтэн, Тайваний Улс төрийн дээд сургуулийн Үндэстэн судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудаас дээрх сэдвээр эрдмийн зэрэг горилсон бүтээлүүд нэлээд гаргадаг байна. Энэхүү зохиол Монгол-Түвдийн Хорооны ажилтан, Монголыг хариуцсан мэргэжилтэн Ван Вэйсугийн докторын зэрэг хамгаалсан бүтээл юм. Энэ нь 6 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

1.Бүлэг: Удиртгал дотроо судалгааны зорилго судлах арга, сурвалж бичиг хэрэглэгдэхүүн зэрэг зүйлийг багтаасан байна. II Бүлэг: 90-ээд оны Гадаад Монголын улс төр эдийн засгийн өөрчлөлт шинэчлэл болон гадаад бодлогын тухай, 1. 90-ээд оны өмнөх Гадаад Монгол-Коммунист Хятадын харилцаа /Тайваньд Монгол улс, БНХАУ-ыг ингэж нэрлэдэг-Ч.Б/ 2.Улс төр эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлийн байдал. III Бүлэг: Гадаад Монгол болон Коммунист Хятадын улс төрийн харилцаа. 1.Төрийн дээд хэмжээний айлчлал болон гэрээ хэлэлцээр. 2.Орон нутаг, хот хоорондын шууд харилцаа. 3.Улс төрийн намуудын гадаад харилцаа. 4 Хоёр талын харилцааны онцлог. IV Бүлэг: Гадаад Монгол болон Коммунист хятадын улс төр эдийн засгийн харилцаа. 1.Чухал арга хэмжээ. 2.Хөрөнгө оруулалт болон худалдаа . 3. Зээл тусламж, V Бүлэгт: Гадаад Монгол болон Коммунист Хятадын улс төр, эдийн засгийн харилцан туслалцаа, түүний сөрөг нөлөө. 1.Улс төр , эдийн засгийн хамтын ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, 2.Гадаад Монгол болон Тайваний харилцаа. VI бүлэг. Дүгнэлт зэрэг багтаж байна.

“90-ээд оны Гадаадын Монголын улстөр, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэл, гадаад бодлогын тухай”д гэсэн II бүлэгтээ 90-ээд оноос өмнөх монголын улс төр, эдийн засгийн байдал нэг загварт байсан ба 90 оноос монголын улс төр, эдийн засгийн амьдралд өөрчлөлт гарч, гадаад дотоод бодлого, улс төр, эдийн засгийн шинэ орчин, шинэ нөхцөл үүссэн тухай өгүүлжээ. Мөн бүлгийн нэгдүгээр зүйлд 90-ээд оноос өмнөх Монгол Хятадын харилцааны талаар бүр 1949 онд БНХАУ байгуулагдмагц БНМАУ БНХАУ-тай дипломат харилцаа тогтоож, 1952 онд БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай гэрээ байгуулсныг үечлэн бичсэн байна. 60-аад оны үед Хятад Оросын харилцаа тааламжгүй болж эхэлсэн нь Монгол Хятадын

<sup>x</sup> Ч.Батцэцэг. ШУА-ийн Олон Улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

харилцаанд шууд муугаар нөлөөлж, 70-аад оны үед харилцаа улам муудаж зогсонги байдалтай болсон гэж зохиогч тэмдэглэжээ.

Харин 80-аад оноос Монгол Хятадын харилцааны царцанги байдал аажмаар тавигдаж эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа сэргэж эхэлсэн юм гээд зохиогч өөрийн дүгнэлтээ хийсэн байна. Үүнд:

**Нэгдүгээрт,** Улсын гадаад хүчин зүйл. 1/Олон улсын улс төрийн байдал өөрчлөгдөж, ардчилал болон коммунист дэглэмийн хоорондын харилцаан дахь сөргөлдөөнд эргэлт гарч, олон улс орнууд эдийн засаг, улс төрийн шинэ тогтолцоонд алхан орж буй үйл явцыг тодорхойлон, Гадаад Монгол нь Зүүн Европ болон Өрнөдийн орнуудтай, ялангуяа Азийн орнуудтай эдийн засаг худалдааны харилцаа хамтын ажиллагаагаа эрчимтэй хөгжүүлж эхэлснийг дурьджээ. 2/Хятад Оросын харилцаа тогтвортой болж байна.

Үүнийг Коммунист Хятадын хувьд авч үзэхэд тэдний өөрчлөлт шинэчлэлийн байдал үндсэндээ стратегийн шинж чанартай гэдгийг нягтлан анхаарах хэрэгтэй.

Оросын талаас бол Оросын гадаад харилцаан дахь өөрчлөлтөд Гадаад Монгол нь зөвхөн шатрын хүү юм. Коммунист Хятадтай харилцаагаа сайжруулахын тулд Орос улс өөртөө ашигтай байхаар бол Гадаад Монголыг золионд ч гаргаж болох цаг үе ирэх магадлалтай. Гадаад Монголын хувьд бол зөвхөн Оросын Холбооны Улс Коммунист Хятадын хоорондын найрсаг харилцааг талархан дэмжих явдал юм. Энэ нь нэг талаар ашигтай боловч бас сөрөг нөлөөтэй, тиймээс бодит үр дүнгээ л сайн тооцоолох хэрэгтэй. 3/ Коммунист Хятадад хэрэгжиж буй өөрчлөн байгуулалтын нөлөөлөл: Коммунист Хятадын эдийн засгийн байдлыг ажиглахад, Ази болон Европын худалдаанд үүд хаалгаа нээж улмаар Бээжингээс Улаанбаатараар дамжин Европ хүртэлх тээврийн шугамыг ашиглаж чадвал амжилтанд хүрэх гол зам болно. Тийм учраас Гадаад Монголтой харилцаагаа сайжруулах хүсэлтэй нь зүйн хэрэг.

**Хоёрдугаарт,** Улсын дотоод хүчин зүйл. 1/Улс төрийн хувьд Гадаад Монголын Сайд нарын Зөвлөлийн дарга Цэдэнбалын үеийн Оросын талыг баримтлагчдын үе нэгэнт дууссан. Одоо бол Гадаад Монгол жинхэнэ утгаараа бусад улс оронтой нээлттэй байх хамгийн сайхан цаг үе юм. 2/ Эдийн засгийн хөгжлийн гол судас нь бүхэлдээ Оросын тогтолцоог авсантай холбоотой. Цаашид Гадаад Монгол нь Зүүн Европын болон Өрнөдийн орнуудтай харилцаагаа өргөжүүлэх сонирхолтой байгаа ч юуны өмнө тээвэр холбоо дэд бүтцийн асуудал чухал бөгөөд өөрийн эдийн засгаа хөгжүүлэхийн тулд Гадаад Монгол Коммунист Хятадтай харилцаагаа эрчимжүүлэн сайжруулах нь зайлшгүй.

**Гуравдугаарт,** Улсын батлан хамгаалахын хувьд, Гадаад Монгол Коммунист хятадын харилцаа сайжирвал Гадаад Монголын улсыг батлан хамгаалах зардлыг хөнгөвчилж болох юм. Гадаад Монголын дотоод гадаад хүчин зүйл 90-ээд оноос эхлэн өөрчлөгдөхөд БНХАУ болон ОХУ-ын харилцаанд мөн өөрчлөлт гарчээ. Ийнхүү 90-ээд онд хүйтэн дайн дууссаны дараа эдгээр гурван өнцөгт харилцаа албан ёсоор өөрчлөгдсөн байна. Гадаад Монгол нь БНХАУ, ОХУ-тайтэгш эрхтэй харилцах болсон юм. Гэвч Оросын эдийн засгийн байдал хүнд байгаагаас Монгол Хятадын харилцаа нь Монголын хувьд эдийн засгийн гол зангилаа болжээ. Иймээс Монгол улс төрийн хувьд Хятад Оростой эрх тэгш харилцаж, харин эдийн засгийн

талаар Хятадтай харилцах гадаад бодлогын хэтийн зорилт болж байна гэж зохиогч дүгнэжээ.

Монгол Улс 80-аад оны эхэн үеэс “төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг бүрэн төгсөөр нь сайшаан дэмжиж байсан” бол 1988 оноос л сая албан ёсоор эдийн засгийн шинэчлэлт явуулж, үйлдвэр аж ахуйн нэгжийг гэрээ түрээсийн зарчмаар хувь хүн болон албан газруудад эзэмшүүлж эхэлжээ. 1988 оны 12 дугаар сарын сүүлчээр МАХН-ын 19 дэх удаагийн Ү бүгд хурал хуралдаж, улс төрийн бодлогын чиг шугамдаа тодорхой өөрчлөлт хийх тухай албан ёсны санал дэвшүүлсэн байна. Үндсэн хууль, намын хөтөлбөрийг өөрчлөн засварлах хороо байгуулан ажлаа эхэлсэн бөгөөд эн тэргүүнд сонгуулийн хуулийн төсөл гаргажээ.

1990 оны 3 дугаар сард Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын төв талбайд жагсаал цуглаан болж 3 өдөр өлсгөлөн зарлаж, ардчилсан өөрчлөлт хийх шаардлага тавьсан юм. Мөн оныхоо 7 дугаар сард Монгол Улсын анхны Их Хурлын сонгууль явуулахад МАХН 85%, бусад намаас 40% санал авснаар Монгол Улс албан ёсоор ардчилсан өөрчлөлт хийж эхлэсэн үе гэж үзэж болно.

1991 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Монгол улсын 12 дахь удаагийн АИХ-ын нээлтийн ажиллагаа болж 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр шинэ Үндсэн хууль баталсан байна. Шинэ Үндсэнхуулийг мөн оны 1-р сарын 13-ны өдрөөс албан ёсоор хэрэгжүүлж эхлэв. Энэ нь Монгол Улс тогтноос хойш 4 дэх удаагийн Үндсэн хууль юм. Мөн БНМАУ гэдэг нэрийг өөрчилж Монгол улс болгож, төрийн сүлд, далбаагаа шинэчилсэн байна. Хамгийн чухал нь шинэ “Үндсэн хууль” баталснаар Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн загвараа өөрчилж, зах зээлийн эдийн засгийн хууль эрхийн үндсийг тавьсанд оршино. Улс төрийг ардчилах, эдийн засгийг чөлөөтэй болгох, гадаадын хөрөнгийг татан оруулах талаар чухал чухал арга хэмжээ авч эхэлсэн нь гадаад улс орнуудын анхаарлыг татаж байна.

Зохиогч 1992 оны сонгуулийн талаар дэлгэрэнгүй тайлбар хийж хүснэгтээр үзүүлсэн байна. Хэдийгээр энэ удаагийн сонгуульд МАХН ялалт байгуулж бусад нам цөөн асуудал авсан ч ардчилсан сонгууль байсан гэдгийг тэрбээр хүлээн зөвшөөрчээ. Харин 1996 оны 6 дугаар сард явагдсан хоёр дахь удаагийн сонгуульд анхныхаасаа олон нам, нийт улс төрийн 11 нам оролцсон бөгөөд үүний үр дүнд Монгол улсад олон намын тогтолцооны үндэс суурь тавигдсан байна гэжээ.

1996 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсын Их Хурлын хаврын чуулганаар Монгол улсыг хөгжүүлэх хөтөлбөр гаргасан байна. Энэхүү хөтөлбөрийг таван жил, ойрын, хэтийн төлөв гэж хуваан эдийн засгийн хөгжлийг гурван үе шаттайгаар авч үзсэн байна. Үүнд: I үе. 1996-2000 он. Энэ хугацаанд эдийн засгийг сэргээн сайжруулах эдийн засгийн үндсэн үр ашгийг нэмэгдүүлэх. II үе. 2001-2010 он. Энэ хугацаанд эдийн засгийн бүтээн байгуулалтыг улам гүнзгийрүүлэн, экспортыг нэмэгдүүлэх аргаар эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх. III үе. 2010-2020 он. Шинжлэх ухаан, тэргүүний техник технологийг чухалчлан хөгжүүлж, өрсөлдөөний арга барилыг шинэчилж, биеэ даасан экспортын эдийн засгийн хэлбэрийг бий болгох зорилт тавьжээ. Мөн түүнчлэн үйлдвэр аж ахуйн газрын 60%-ийг хувьчлах талаар заасныг дурьдаад Монгол улсын эдийн засагт хувьчлал маш их нөлөө үзүүлнэ, нийгмийн энэ өөрчлөлт шинэчлэлийн үед Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр маш чухал гэдгийг онцлон

тэмдэглэжээ. Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалт хийх эдийн засгийн байдлаар нь бүсчлэн хөгжүүлэх талаар гаргасан хуулиуд ялангуяа 1993 оны 5 дугаар сард баталсан хөрөнгө оруулалтын тухай хуулийн гол агуулгыг зүйл ангиар нь тодорхой тусгажээ.

Нөгөөтэйгүүр Монгол улсын засгийн газар Орос улсаас салснаас хойш, улс төр, эдийн засгийн өөрчлөн байгуулалтын талаар авч буй арга хэмжээ, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх үндсийг тавьсан хэдий ч монголын эдийн засагт хөдөлмөрлөх хүч дутагдалтай, тээвэр холбоо дэд бүтцийн байдал харьцангуй дорой, бүтээн байгуулалтын хөрөнгө мөнгө, санхүүгийн байдал бэрхшээлтэй, байгалийн баялаг ихтэй боловч олдворлох, боловсруулах хүчин чадал нөхцөл муу зэрэг онцлогууд байна. Мөн Орос улсаас зээл тусламж өгөхөө больсноос хойш эдийн засгийн урт хугацааны мухардалд орж, ард түмний амьжиргааны төвшин муудаж, ядуучуудын тоо эрс нэмэгдэж, улс төрийн байдал тогтворгүй болж байна гэжээ. 1998 оны байдлаар нийт хүн амын 36% нь нэн ядуу амьдралтай байна. Дэлхийн Банкны судалгаагаар 1997 оны үндэсний нийт бүтээгдэхүүн 360 ам.доллар байна. /Дэлхийн банкны энэхүү судалгаанд нийт 64 орон хамрагдсаны хамгийн бага орлоготой улсын нэг болжээ/. Сүүлийн 7 жилд ажилгүйчүүдийн тоо эрс нэмэгдснийг дурьдаад 1991-1997 оны хоорондох ажилгүйчүүдийн харьцуулсан судалгаа хүснэгтээр үзүүлсэн байна.

Мөн хөдөөнөөс хот суурин газар руу шилжин суурьших хүний тоо эрс нэмэгдсэн. Бараа таваарын үнэ өсч, үйлдвэр зогсонги байдалд орсон нь ерх гэр, хүмүүсийн амьдралд хүнд тусчээ. Нийгмийн хэв журам аюулгүй байдлын талаар Цагдаагийн байгууллагын мэдээнээс үзвэл 1997 оны хоорондох ажилгүйчүүдийн харьцуулсан судалгаагаар хүснэгтээр үзүүлсэн байна.

Мөн хөдөөнөөс хот суурин газар руу шилжин суурьших хүний тоо эрс нэмэгдсэн. Бараа таваарын үнэ өсч, үйлдвэр зогсонги байдалд орсон нь ерх гэр, хүмүүсийн амьдралд хүнд тусчээ. Нийгмийн хэв журам аюулгүй байдлын талаар Цагдаагийн байгууллагын мэдээнээс үзвэл 1997 онд нийт гэмт хэргийн тоо 2,47%-иар нэмэгдэж, урьд оныхоос 10,29%-иар өссөн гэсэн жишээ баримт авчээ.

3. Гадаад бодлогын тухайд. Монгол улс өргөн удам нутагтай, хүнам цөөнтэй, цэргийн үйл ажиллагаа хүчин чадлаар сул дорой учир улсын хөгжил болон аюулгүй байдлын хувьд улсын хилийн эргэн тойрон найрсаг харилцаа, дэмжлэг маш чухал. Иймээс Монгол улс дотооддоо улс төр, эдийн засгийн өөрчлөлт хийхийн сацуу гадаад бодлогоо зөв боловсруулах ажил хийж байна. Зохиогч Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол улсын цэргийн номлолын үндэс, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг тодорхой тусгаад уг баримт бичгүүдэд Монгол Улсын гадаад бодлогын уламжлалт найрамдалт харилцааг үндэс болгосон байна гэж бичжээ. Мөн төрийн албан ёсны айлчлалыг он оноор нь хүснэгтээр үзүүлэн хавсралт хийсэн байна.

III бүлэг. Монгол улс БНХАУ-ын улс төрийн харилцаа.

90-Ээд оны Монгол улс гадаад бодлогодоо өөрчлөлт оруулж, БНХАУ-тай улс төрийн найрсаг харилцаатай байхыг чухалчилж иржээ. Энэ ч аргагүй юмаа. Учир нь энэ хоёр улс 4673 гаруй км газраар хиллэдэг, өнө эртний харилцаатай улс юм. 90-ээд оноос хоёр тал улс төрийн, аймаг, хотын, намын харилцаа гэсэн 3 чиглэлээр харилцаагаа улам нягт хөгжүүлж байна.

Зохиогч мөн энд төрийн дээд хэмжээний уулзалт, гэрээ хэлэлцээр, баримт бичигт гарын үсэг зурсан байдлыг он дарааллаар гаргажээ.

Монгол улс гадаад улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхдээ ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана. Эдгээр оронтой харилцахдаа хөрш орнуудаас Монгол улсын үндэсний ашиг сонирхлын талаар баримталж буй бодлогыг зохих ёсоор харгалзан тусгаж байх. Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд эс оролцож төвийг сахих бодлого явуулна гэж манай Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан байдаг билээ.

1994 онд байгуулсан Монгол улс БНХАУ-ын харилцаа хамтын ажиллагааны тухай Гэрээ нь Монгол, Хятадын харилцааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, харилцаа хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүдийг зааснаараа ач холбогдолтой юм. Зохиогч улс төрийн гадаад харилцаа бол хоёр орны найрсаг харилцааны чухал ажлын нэг мөн гээд орон нутаг, аймаг хотуудын хоорондын харилцаа, ялангуяа Өвөр Монголын Өөртөө Засах Оронтой харилцаж буй хамтын ажиллагаагаа өргөжүүлж байгааг жишээ баримттай дурьдсан байна. Харин хоёр талын харилцааны онцлогт хоёр орны эдийн засгийн харилцаа, худалдааны хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, зээл тусламжийн асуудлаар авч буй арга хэмжээнүүдийг заажээ.

Тус зохиолдоо Монгол-тайваны харилцаа гэсэн зүйл оруулсан байна. Монгол улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж, БНХАУ эдийн засгийн шинэчлэл хийж байгаа нь хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Монгол, Тайвань харилцаж ирсэн 90-ээд оны эхэн үеэс шинжлэх ухаан боловсролын салбарт эрдэмтэд солилцох, хэлний мэргэжил дээшлүүлэгчдийг сургах, урлаг соёлын төлөөлөгчдийг урьж тоглолт хийлгэх, эдийн засгийн салбарт монголын ажил хэрэгч хүмүүст /бизнесменүүдэд/ гадаад худалдаа олон улсын эдийн засгийн чиглэлээр сургалт явуулах, хөрөнгө оруулалт, жижиг, дунд үйлдвэрийн асуудлаар уулзалт, хурал зохион байгуулах, Монголд тусламж үзүүлэх ажлыг явуулах, Тайваниас жуулчин явуулж монголын түүх соёлтой танилцах аялал хийлгэх зэрэг ажил зохион байгуулж иржээ. Дээрх ажлуудыг Тайвань дахь Монгол Түвдийн Хорооноос санаачлага гарган тэдний оролцоо дэмжлэгтэйгээр хийгдэж байна.

Монгол улс Тайваньтай улс төрийн харилцаа явуулдаггүй, Тайванийг тусгаар тогтносон улс хэмээдэггүй гэж төрийн тэргүүнүүдийн албан ёсны мэдэгдлүүдээс ишлэл болгон авчээ. Энэ нь ч үнэн юм. "БНХАУ-ын Засгийн газар бол Хятад улсыг төлөөлсөн хууль ёсны цорын ганц Засгийн газар бөгөөд Тайвань бол БНХАУ-ын нутаг дэвсгэрийн салшгүй нэг хэсэг мөн" гэж Монгол Хятадын хамтарсан албан мэдээнд өгүүлсэн байдаг. Тайваньчууд "Гадаад Монгол бол манай салшгүй хэсэг" гэсэн байр суурь баримтлан Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрдөггүй тэр л үзэл санаа энэхүү нэгэн сэдэвт зохиолд мөн л цухалзсаар байна. Гэвч энэ бүтээлдээ зохиогч сүүлийн үеийн шинэ шинэ мэдээ сэлт элбэг оруулж, өөрийн дүгнэлт, харьцуулалтыг өргөн ашигласан нь чухал ач холбогдолтой болжээ.